


УЛААНБААТАР ХОТЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН
ТӨВӨӨС НИЙСЛЭЛИЙН ИНЖЕНЕРИЙН ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЛБАН
ХААГЧДЫН ДУНД ЯВУУЛСАН СУДАЛГААНЫ ДҮН МЭДЭЭ

2022 оны 10 дугаар сарын 31

Улаанбаатар хот

Уг судалгааг Төвийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд үндсэн үйл ажиллагааг сайжруулах, Улаанбаатар хотын инженерийн хангамжийн байгууллагууд хоорондын уялдаа холбоо ямар түвшинд байгааг үнэлэх зорилгоор Нийслэлийн нийт албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа “Ulaanbaatar ERP” системийн тусламжтайгаар /Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК, Ус сувгийн удирдах газар, Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар, Улаанбаатар Зам засвар, арчлалтын газар, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар, Геодези, усны барилга байгууламжийн газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв, Хот тохижилтын газар, Хувийн орон сууц, нийтийн аж ахуйн Хөгжлийн төв ТББ/ нийт 10 байгууллагыг хамруулан 2022 оны 10 дугаар сарын 12-ноос 18-ны өдрүүдэд зохион байгуулж, дүн мэдээг нэгтгэн ажиллалаа. Судалгааг нийт 7 асуултын дагуу явуулсан бөгөөд 254 албан хаагч хамрагдсан. Үүнд:

Асуулт 1: Та Төвийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ямар эх сурвалжаас авдаг вэ?




Дээрх асуулгад нийт 229 албан хаагчид хамрагдсан ба үүнээс 21.83% нь Цахим хуудас /www.discenter.ub.gov.mn/-наас, 22.27% нь Шуурхай утас /11-310005/-наас, 22.71% нь Facebook хуудаснаас, 33.2% нь бусад эх сурвалжаас гэж хариулсан байна.

Асуулт 2: Та манай Төвтэй ямар чиглэлээр илүү холбогдож ажилладаг вэ?




Нийт 169 албан хаагч дээрх асуулгад хамрагдсан ба үүнээс 31.95% нь Иргэдийн гомдол мэдээллийн мөрөөр, 45.45% нь Инженерийн шугам сүлжээтэй холбогдолтой асуудлаар, 15.98% нь Зохицуулалт хийлгэх зорилгоор, 6.51% нь Бусад чиглэлээр гэж хариулсан байна.

Асуулт 3: Төвийн Диспетчер инженерүүд нь “Харьцааны заавар”-ын дагуу ажил үүргээ гүйцэтгэж байгаа эсэх?




Нийт 153 албан хаагч асуулгыг бөглөснөөс 57.52% нь Сайн, 39.22% нь Дунд, 3.27% нь Хангалтгүй гэж хариулжээ.

Асуулт 4: Инженерийн шугам сүлжээ, байгууламжид аваар, саатал гарч горим ажиллагаа доголдсон тохиолдолд Төвийн диспетчер инженер нь оновчтой арга хэмжээ авч, шуурхай зохицуулалтыг хийж байгаа эсэх?




Нийт 146 албан хаагч дээрх асуулгыг бөглөснөөс 8.9% нь Маш сайн, 60.96% нь Сайн, 28.08% нь Дунд, 2.05% нь Хангалтгүй гэж хариулсан байна.

Асуулт 5: Танай байгууллагын үйл ажиллагааны чиглэлд Төвөөс холбогдож, дэвшүүлсэн асуудлууд нийцэж байгаа эсэх?



Нийт 144 албан хаагч дээрх асуулгыг бөглөснөөс 54.17% нь Тийм, 6.25% нь Үгүй, 39.58% нь Мэдэхгүй гэсэн хариулт өгчээ.

Асуулт 6: Төвөөс тавьж байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд хүндрэл үүсэж байгаа эсэх?



141 албан хаагч дээрх асуулгад хамрагдсан ба үүнээс 8.51% нь Тийм, 48.94% нь Үгүй, 42.55% нь Мэдэхгүй гэж хариулсан байна.

Асуулт 7: Хот, нийтийн үйлчилгээний тасралтгүй, хэвийн ажиллагааг хангуулахад байгууллага хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог улам сайжруулах, цаашид зайлшгүй авч хэрэгжүүлэх, зохицуулалт хийх шаардлагатай асуудлын талаар саналаа бичнэ үү?


Нийт 46 албан хаагч санал бичиж ирүүлсэн бөгөөд давхардсан саналыг нэгтгэн харуулбал:

- Инженерийн хангамжийн байгууллагуудын уялдаа холбоог улам сайжруулж, хамтран ажиллах гэрээ, харьцааны заавар байгуулж ажиллах.
- Шугам сүлжээнд аваар, саатал гарсан үед холбогдох зохицуулалтыг цаг алдалгүй гүйцэтгэх.

- Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх ажлын гүйцэтгэлийг эргэж тухай бүр шуурхай мэдэгдэх.
- Инженерийн шугам сүлжээний зааг эзэмшлийг тодорхой болгож, харьяаллын бус дуудлага мэдээлэл хүлээн авч шилжүүлэхгүй байх. Дундын эзэмшлийн шугамын засвар үйлчилгээг хэн хариуцан ажиллахыг тодорхой болгох аль эсвэл зааг эзэмшил нь тодорхойгүй дундын эзэмшлийн шугам сүлжээний засвар үйлчилгээ хийдэг тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай болох.
- Иргэд, оршин суугчид болон аж, ахуй нэгж байгууллагуудад үзүүлж буй нийтийн үйлчилгээг ил тод болгож, олон шат дамжлагыг багасгах. Мэдээ мэдээллийг цахимжуулж, нэгдсэн системтэй болгох.
- Хувийн орон сууцны конторуудын бүртгэл мэдээллийг санг шинэчилж, сайжруулах. Цаашид нэгдсэн бодлого зохицуулалтаар ажиллах боломжийг бүрдүүлэх. Тусгай зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллагууд дээрх аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд тавих хяналт, эргэх холбоог сайжруулах.
- ШУЗТ-өөс ажлыг цахимаар нээлттэй явуулж, иргэд болон байгууллагуудад мэдээллийг шуурхай хүргэж байх.

Дүгнэлт

Судалгаанд оролцогч 254 албан хаагчаас 125 албан хаагч судалгааны асуултыг бүрэн гүйцэт бөглөж илгээсэн бол 129 албан хаагчид судалгааг дутуу бөглөж илгээсэн байна.



1-р асуултын хүрээнд Төвийн үйл ажиллагааны талаар ерөнхий мэдээллийг цаашид Төвийн цахим хуудсаар дамжуулан хүргэх, цахим хуудсыг улам хөгжүүлэх, сурталчлан таниулах шаардлагатай нь судалгааны дүнгээс харагдлаа.

3 болон 4-р асуулт буюу Төвийн Ахлах болон диспетчер инженерүүдийн ур чадвар, оновчтой шийдвэрийн талаарх асуултын хариултаас харахад Сайн гэсэн үнэлгээ давамгайлж байгаа нь албан хаагчдын ур чадварт тодорхой хэмжээний ахиц гарсныг харуулжээ. Мөн Диспетчер инженерүүдийн ёс зүй, харьцааны талаарх асуулгыг 2021 оны судалгааны дүн мэдээтэй харьцуулахад сайн гэсэн хариулт 12.88%-иар өссөн бол Хангалтгүй гэсэн хариулт 11.21%-иар буурсан үзүүлэлттэй байгаа нь сайшаалтай байна.

5-р асуултын хүрээнд 78 буюу 54.17% нь тийм гэсэн хариултыг, 6-р асуултын хүрээнд 69 буюу 48.94% нь үгүй гэсэн хариултыг өгсөн нь Төвийн хэмжээнд хэрэгжиж байгаа үйл ажиллагаа оновчтой, аж ахуй нэгж байгууллагуудаас ирүүлсэн гомдлыг шийдвэрлэхэд хүндрэл учирдаггүй гэсэн эерэг үзүүлэлтүүд гарчээ.

7-р асуултын хүрээнд судалгаанд оролцогчдын 18.11% буюу 46 оролцогч саналаа ирүүлсэн бөгөөд Инженерийн хангамжийн байгууллагуудад Төвийг сурталчилж, үйл ажиллагааг ил тод болгох, хамтын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах талаар тус тус санал ирүүлснийг Төвийн зүгээс үндсэн үйл ажиллагаандаа тусган, хэрэгжүүлж ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

ТАНИЛЦСАН: ДАРГА

Ц.БАНЗРАГЧ

ХЯНАСАН:

ДОТООД ХЯНАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.БАДАМЖАВ

ДҮН МЭДЭЭ ГАРГАСАН:

БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ЭНХТУУЛ